

БАТЛАГ  
СУМЫН ИТХ-ЫН ДАРГА Б.ГАНБАТ

2019 оны ... сарын ... ны өдөр

### ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ № 04

Энэхүү гэрээг нэг талаас **Өвөрхангай** аймаг **.Уянга** сумын Засаг дарга ажилтай **Б.Доржтоогоо** (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас: тус сумын **Модот мухарын МУ007014** дугаартай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч **Өгөөмөр өргөө** ХХК -ийг төлөөлж **Захирал** ажилтай **С.Дорждагва** нар (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 06 дугаар сарын 17 ны өдөр **Өвөрхангай** аймаг **Уянга** суманд байгуулав.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

#### Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.2. энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;

2.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

#### Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ::

3.1.1. орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.2. хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.1.3. нийт ажлын байрны 30 аас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;

3.1.4. өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;

3.1.5. хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн сумын иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

3.1.6. бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.1.7. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.8. гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

3.1.9 Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилтын хүрээнд:

- Байгууллагын орчныг тохижуулах, хог хаягдалаа устгах, сумын төвийн хог хаягдлыг зайлуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Улс, аймаг, суманд төлөх татварыг хуулийн хугацаанд төвлөрүүлэх, тайланг хугацаанд нь гаргах
- Ажиллагсадаа эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлд бүрэн хамруулах
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, журмыг чанд мөрдөж ажиллах
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу бүрэн хийнэ.
- Аж ахуйн нэгжийн тайлангаа хугацаанд нь гарган тайлагнах.
- Нийгмийн хариуцлагын гэрээний биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

3.1.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- Монгол Улсын Эрүүл мэндийн гавьяат ажилтан Д.Наваанд хүндэтгэл үзүүлэх 3,5 / гурван сая таван зуу/ мянган төгрөгийн гэр бэлтгэх/ 2019 оны 7 дугаар сарын 05 ны дотор/



- Цагдаагийн байгууллагын §0 жилийн ойг тохиолдуулан сумын Цагдаагийн тасагт компьютер авахад 800,0 / найман зуун / мянган төгрөг, 2019 оны 07 дугаар 20 ны дотор
- Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 2,0 / хоёр/ сая төгрөг, 2019 оны 07 дугаар 30 ны дотор
- Битүүт, Өвөрхятрууны чиглэлийн замыг засаж сайжруулах/ Тухайн үед зарцуулсан төсвөөр/ 2019 оны 09 дүгээр 30 ны дотор

#### **Дөрөв. Хамтын ажиллагааны хороо**

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороог Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

#### **Тав. Гэрээний хэрэгжилт**

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. .

5.2. Талууд гэрээний биелэлтийг 11 дүгээр сарын 20 ны дотор дүгнэж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 20 -ний дотор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

#### **Зургаа. Гэрээний хариуцлага**

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

#### **Долоо. Маргаан шийдвэрлэх**

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв .зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

#### **Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох**

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш тухайн оны 12 дугаар сарын 31 ны өдрийг дуустал хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.


8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ

АШИГТ МАЛТМАЛЫН БАЙГУУЛЛАГЫГ

ТӨЛӨӨЛЖ,  
УЯНГА СУМЫН ЗАСАГ  
ДАРГА  Б.ДОРЖТОГОО

ТӨЛӨӨЛЖ,  
ӨГӨӨМӨР-ӨРТӨӨ ХХК –ИЙ  
ЗАХИРАЛ С.ДОРЖДАГВА  
